



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар АА69

Булган сум

Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх  
16 хоногийн аяныг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1.6, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны XXV дугаар хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XXV/05 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны “Хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг батлах тухай” А/633 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний хэмжээнд өрнүүлж буй жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг аймгийн хэмжээнд “ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮД ХААНА Ч АЮУЛГҮЙ-ШАЛТАГ БҮҮ ТООЧ” уриан дор иргэд олон нийтэд сурталчлан таниулах ажлыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үр дүнтэй зохион байгуулсугай.

2. Аяныг зохион байгуулах ажлын нэгдсэн удирдамжийг 1 дүгээр, аяны хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар, аян зохион байгуулахад шаардагдах төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг зохион байгуулахад шаардагдах 5,456,000 (таван сая дөрвөн зуун тавин зургаан мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийг хэрэгжүүлэх хөтөлбөр” хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

4. Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулж, хяналт тавьж ажиллан, үр дүнг нэгтгэн 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр тайлагнахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА


Д.ПҮРЭВ-ОЧИР



Сугар Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324011137

12 дугаар сарын 04-ны өдөр  
Аймгийн Засаг даргын 2024 оны  
АТБС дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



**ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ 16 ХОНОГИЙН АЯНЫ ХҮРЭЭНД ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ, МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ “ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮД ХААНА Ч АЮУЛГҮЙ – Шалтаг бүү тооч!” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

**Үндэслэл:** Жендэрт суурилсан хүчирхийлэл гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алины эсрэг тэдний хүйсийн байдлаас үүдэн үйлдэгдсэн хүчирхийлэл, дарангуйлал бөгөөд бие махбод, бэлгийн болон сэтгэл зүйн хохирол учруулахыг хэлнэ. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд үүссэн эрх мэдлийн тэгш бус харилцаа нь жендэрт суурилсан хүчирхийллийн гол хүчин зүйл болдог. Жендэрт суурилсан хүчирхийлэл нь гэр бүлийн хүчирхийлэл, охид эмэгтэйчүүдийн эсрэг, бэлгийн хүчирхийлэл, ажлын байрны бэлгийн дарамт, хүн худалдаалах зэрэг хүчирхийллийн хэлбэрүүдээр илэрхийлэгддэг. Иймээс охид, хөвгүүд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж байгаа жендэрт суурилсан хүчирхийллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлж, хүчирхийллээс ангид аюулгүй, хүний эрхийг хамгаалсан орчныг бий болгоход олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээ мэдээллийг түгээх шаардлагатай байна.

**Зорилго:** Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, жендэрт суурилсан хүчирхийлэл түүний хор уршгийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, нуугдмал гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд дэмжлэг үзүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийт, эрэгтэйчүүд, хөвгүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

**Удирдлага зохион байгуулалт:** Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Хууль эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, эрүүл мэндийн газар, Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах алба, Сайхан Монгол телевиз, Сумдын Засаг дарга нар хамтран зохион байгуулна.

**Хугацаа:** 2024 оны 12 дугаар сарын 04-өөс 12 дугаар сарын 10-ний өдөр хүртэлх хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулна.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**


- ❖ Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны хүрээнд олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮД ХААНА Ч АЮУЛГҮЙ – Шалтаг бүү тооч!” сэдэвт (Reel) бичлэгийн уралдааныг 2024.12.04-2024.12.10 хүртэлх хугацаанд цахим орчинд нээлттэй зохион байгуулж, шилдэг 3 байр шалгаруулж, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.
- ❖ 16 хоногийн аяныг илтгэсэн хүчирхийллийн эсрэг “Нэг тэр бумаараа нэгдэцгээе” флаш моб бүжгээр байгууллага, хамт олноороо нэгдэж, бичлэг хийн давлагаалж, байгууллагын цахим хаягаар сурталчлах. (Хүчирхийллийн эсрэг нэгдэж бүхий л үйл ажиллагаанд “Улбар шар” өнгийг ашигласан байх.)

- ❖ ХӨУБ-ын хүүхдүүдийн идэвх оролцоотойгоор үе тэнгийнхэндээ нөлөөлөх санаачилгыг өрнүүлэх, тэдгээрийн хийж буй нөлөөллийн ажлыг цахим орчин, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон гудамж, талбайн LED дэлгэцээр цацах, хүчирхийллийн эсрэг “Улбар шар” өнгийг илэрхийлсэн прэм хийх.
- ❖ Цагаан туузны аянд нэгдэх арга хэмжээг байгууллага бүр зохион байгуулж, аянтай холбоотой лого, стикер, хамт олны уриалгын хамт байгууллагын цахим хаягт байршуулах.
- ❖ Хүүхэд өсвөр үе, насанд хүрэгчдэд зориулсан сургалт нөлөөллийн ажил өрнүүлж, үр дүнг тооцон ажиллах.
- ❖ Аймгийн жендэрийн статистик судалгаа бүхий гарын авлага гарган албаны хэрэгцээнд ашиглах.
- ❖ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгоор насанд хүрэгчдэд зориулсан “Хүчирхийлэлд хүйс хамаарах уу?” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулах.
- ❖ Охид ба хөвгүүд арга хэмжээ зохион байгуулж, тэдний үзэл бодлыг сонсож, зөв ойлголт, мэдээлэл өгөх.
- ❖ Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны талаар орон нутгийн телевизэд мэдээлэл өгөх зэрэг ажлуудыг хэрэгжүүлэн ажиллана.

**Мэдээ тайланг нэгтгэж, тайлагнах хугацаа:** 2024 оны 12 дугаар сарын 10-ний өдрийн дотор [baatarsurenmyagmarsuren@gmail.com](mailto:baatarsurenmyagmarsuren@gmail.com) хаягаар ирүүлэх.

**Холбогдох утас:** 88361346, 99341346

...12 дугаар сарын 04-ны/ний өдрийн А/А.69 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт




ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ 16 ХОНОГИЙН АЯНЫ ХҮРЭЭНД “ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮД ХААНА Ч АЮУЛГҮЙ – ШАЛТАГ БҮҮ ТООЧ!” АРГА ХЭМЖЭЭГ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хугацаа: 2024.12.04-12.10-ны өдрийн хооронд

| д/д | Хэрэгжүүлэх ажил  | Хугацаа        | Хариуцах албан тушаалтан        | Хамтран хэрэгжүүлэх байгууллага  |
|-----|---|----------------|---------------------------------|--|
| 1   | 2   | 3              | 4                               | 5  |
| 1   | Арга хэмжээ зохион байгуулах талаар холбогдох талуудад албан бичгээр мэдээлэл өгөх.   | 2024.12.04     | АЗДТГ-ын НБХ                    | ЭМГ, ЦГ, ХГБХХГ, ЭМГ   |
| 2   | Арга хэмжээний хүрээнд уриа, видео шторк, фрэйм, ковер, баннер, лого, постер нийтийн цахим сүлжээгээр түгээх. (Хүчирхийллийн эсрэг өнгө болох “Улбар шар” өнгийн прэмтэй байх)                                      | Аяны хугацаанд | АЗДТГ-ын НБХ, ХМОНХА            | Сумдын ЗДТГ, ЭМГ, ЦГ, ГБХЗХГ, холбогдох байгууллагууд, “Сайхан монгол” телевиз |
| 3   | Арга хэмжээний хүрээнд хулдаасан хэвлэл, санамж, сэрэмжлүүлэг, аяны постер, стикер зэргийг хэвлүүлэн иргэд, олон нийтэд хүргэх.   | Аяны хугацаанд | АЗДТГ-ын ХЭЗХ, Аймгийн ГХУСАЗСЗ | ЦГ, ГБХЗХГ   |
| 4   | Цагаан туузны аянд нэгдэх арга хэмжээг зохион байгуулах.  | Аяны хугацаанд | АЗДТГ-ын НБХ, ХЭЗХ              | Сумдын ЗДТГ, холбогдох байгууллагууд   |
| 5   | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгоор насанд хүрэгчдэд зориулсан “Хүчирхийлэлд хүйс хамаарах уу?” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулах.  | Аяны хугацаанд | ЦГ, ХГБХХГ, ЭМГ                 | АЗДТГ-ын НБХ, ХЭЗХ, Сумдын ЗДТГ  |
| 6   | Мэдээ, мэдээллийн цахим хуудаст /вэб сайтад/ гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээний талаар мэдээлэл өгөх булан ажиллуулах.   | Аяны хугацаанд | ХГБХХГ                          | ЦГ, БШУГ, ЭМГ  |
| 7   | Хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан жендрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт мэдэгдэхүүн өгөх сургалт нөлөөллийн ажил хийх, богино хэмжээний шторк бэлтгэн сургуулийн орчин дахь LED дэлгэцүүдээр цацах, байршуулах. | Аяны хугацаанд | ХГБХХГ                          | Аймгийн хүүхдийн зөвлөл, сургуулийн ХӨУБ-ууд                                   |

|    |   |   |  |   |
|----|---|---|--|---|
| 8  | 16 хоногийн аянг илтгэсэн “Хүчирхийллийн эсрэг 1 тэр бумаараа нэгдэцгээ” флаш моб бүжигт нэгдэх.  | 2024.12.04-12.10                        | АЗДТГ-ын НБХ, ХГБХХГ, БТСГ, ЭМГ                              | Аймгийн хүүхдийн зөвлөл, сургуулийн ХӨУБ-ууд, холбогдох байгууллагууд |
| 9  | Төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгоор насанд хүрэгчдэд зориулсан “Хүчирхийлэлд хүйс хамаарах уу?” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулах. | 2024.12.07 хүртэлх хугацаанд            | ХГБХХГ   | АЗДТГ, ЦГ, ЭМГ  |
| 10 | Охид ба хөвгүүд арга хэмжээ зохион байгуулж, тэдний үзэл бодлыг сонсож, зөв ойлголт, мэдээлэл өгөх.   | 2024.12.04-07                           | ХГБХХГ, БШУГ   | ЭМГ, ЦГ   |
| 11 | Төрийн албан хаагчид, ахлах ангийн сурагчид, иргэд олон нийтэд зориулсан сургалт нөлөөллийн ажил, лекц, зохион байгуулах.   | Аяны хугацаанд                          | АЗДТГ-ын НБХ, ХЭЗХ, ХГБХХГ, ХЭҮК-ын Булган аймаг дахь салбар | Сумдын ЗДТГ, БШУГ, холбогдох байгууллагууд                            |
| 12 | Аймгийн жендэрийн статистик судалгаа бүхий гарын авлага гарган ажлын хэрэгцээнд ашиглах.  | Аяны хугацаанд                          | АЗДТГ-ын НБХ   | Статистикийн хэлтэс, ХХҮГ, ХГБХХГ, ЭМГ, БШУГ, ХХААГ, Сумдын ЗДТГ      |
| 13 | “ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮД ХААНА Ч АЮУЛГҮЙ – Шалтаг бүү тооч!” сэдэвт (Reel) бичлэгийн уралдааныг цахим орчинд нээлттэй зарлах.   | 2024.12.04-2024.12.10 хүртэлх хугацаанд | АЗДТГ-ын НБХ, ХЭҮК-ын Булган аймаг дахь салбар               | ЦГ, ХГБХХГ, АЗДТГ-ын ХМОНХА   |
| 14 | Арга хэмжээний дүн, тайлан мэдээг нэгтгэх.  | 2024.12.04-2024.12.10                   | АЗДТГ-ын НБХ мэргэжилтэн                                     | ЦГ, ГБХЗХГ, Сумдын ЗДТГ   |

Аймгийн Засаг даргын 2024 оны  
12 дугаар сарын 01-ны/ний өдрийн А/Т.60 дугаар  
захирамжийн 3 дугаар хавсралт



ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ 16 ХОНОГИЙН АЯНЫ  
ХҮРЭЭНД “ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮД ХААНА Ч АЮУЛГҮЙ – ШАЛТАГ БҮҮ ТООЧ!” АРГА  
ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨСӨВ

| д/д      | Шаардагдах зардал   | Хэмжих нэгж                            | Нэг бүрийн үнэ                       | Нийт үнэ                    |
|----------|---|--|--------------------------------------|-----------------------------|
| 1        | 2   | 3                                      | 4                                    | 5                           |
| 1        | Хүчирхийллийн эсрэг нэгдэх Улбар шар өнгийн тууз хийх   | 100 ш                                  | 5,000                                | 500,000                     |
| 2        | Аймгийн жендэрийн статистик тоон судалгаа бүхий гарын авлага гарган ажлын хэрэгцээнд ашиглах, холбогдох байгууллагад хүргэх.  | 100 ш                                  | 5,000                                | 500,000                     |
| 3        | Нийгмийн салбарын Статистик тоон үзүүлэлт бүхий иргэдэд танилцуулах самбар хэвлүүлэх  | 8ш<br>240*120                          | 95,000                               | 760,000                     |
| 4        | Самбарын хүрээ  | 8ш<br>240*120                          | 15,000                               | 120,000                     |
| 5        | Хэвлэлийн эх бэлтгэл  | -                                      | 50,000                               | 50,000                      |
| 6        | Аяны хүрээнд ашиглах постер, стикер<br>- Стэнд<br>- Стэнд тогтоох хөл<br>- Хөөсөн стикер – 4 төрөл<br>- Ханын наалддаг стикер | - 180*80<br>- 180*80<br>- 20ш<br>- 10ш | 58,000<br>18,000<br>15,000<br>15,000 | 58,000<br>18,000<br>450,000 |
| 7        | Насанд хүрэгчдэд зориулсан хэлэлцүүлгийн цайны завсарлага.<br>- Цайны сет   | 300ш                                   | 5,000                                | 1,500,000                   |
| 8        | (Reel) бичлэгийн уралдааны шагнал<br>1-р байр<br>2-р байр<br>3-р байр   | 1 хүн<br>1 хүн<br>1хүн                 | 700,000<br>500,000<br>300,000        | 1,500,000                   |
| Нийт дүн |   |  | 5,456,000                            |                             |